



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.04.21 № 1/123

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд Г  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Галуут сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох “Монгол ардын нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Баянхонгор аймгийн Галуут сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2026 оны Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим,

Төрийн аудит MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

“Монгол ардын нам”-ын Баянхонгор аймгийн Галуут сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Монгол ардын нам”-ын мөрийн хөтөлбөр (1/1 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Баянхонгор аймгийн Сонгуулийн хороонд

Хувийг: Баянхонгор аймгийн “Монгол ардын намын хороо”-д

Хавсралт ... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

ХЯНАСАН:  
АУДИТЫН МЕНЕЖЕР

М.АЛТАНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:  
АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА

АУДИТОР

Д.ЦЭДЭВЦЭВЭЭН

Баянхонгор аймгийн Монгол Ардын Намын  
Хорооны Тэргүүлэгчдийн 2024 оны 06 дугаар сарын  
24-ний өдрийн 08 дугаар тогтоолын хавсралт



БАЯНХОНГОР АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН  
ХОРООНООС 2024 ОНЫ АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН  
СОНГУУЛЬД ДЭВШҮҮЛЭН ОРОЛЦОХ  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР  
(2024-2028)

**НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**1.1 Орлоготой иргэн**

Орлоготой иргэн зорилтын хүрээнд аймгийн хэмжээнд гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлэх замаар шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэд, их дээд сургуулиудтай хамтарч технологи, инновац, судалгаа шинжилгээ хийж, орон нутгийн түвшинд хөгжих боломжтой үйлдвэрүүдийг тодорхойлон, үйлдвэржилтийн бодлогыг хэрэгжүүлнэ.

-Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац"-аар дамжуулан бага хүүтэй зээл олголтыг үргэлжлүүлнэ.

-Гарааны бизнесийг дэмжих эко системийг бүрдүүлж, бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

-Өрхийн оёдлын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг бүх сумдад хэрэгжүүлнэ. Хүүхэд бүрийг хадгаламжтай болгох "Хуримтлалтай хүүхэд" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

-Хүүхэд бүрийг хадгаламжтай болгох "Хуримтлалтай хүүхэд" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

-Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжинэ.

-Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг орон нутгаас дэмжин "Ажилсаг төв"-ийн үйлчилгээгээр бойжуулан хөгжүүлэх бодлого баримтална.

-Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд жижиг, дунд бичил бизнесийг дэмжих урт хугацаатай, хүү багатай зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, санхүүжилтийн эх үүсвэрийг тэлэх бодлого баримталж, шударга, ил тод, нээлттэй олгох зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.

## 1.2.Орон сууц

Зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны төлбөрийг бууруулах, чөлөөлөх хөтөлбөрийг боловсруулж үе шаттай хэрэгжүүлэх замаар олон төрлийн орлогод нийцсэн, түрээсийн, ногоон орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, инженерийн хангамжтай орон сууцаар хангана


-Дахин төлөвлөлтөд хамрагдсан өрхийн орон сууцны төлбөрт санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар зорилтот бүлгийн иргэдийн төлбөрийг бууруулах боломжийг бүрдүүлнэ.

-Баялагийн сан, Нийгмийн даатгалын сангаар дамжуулан нийтийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх ажлыг санаачлан хэрэгжүүлнэ.

- “Миний түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд иргэд түрээслэх, түрээслээд өмчлөх орон сууцны төслийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.

## 1.3 Эрүүл иргэн

Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл амьдралын зөв дадлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааны “Жишиг загвар төв” байгуулж, иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, орон нутгийн болон бүх шатлалын эмнэлгүүдийн оношилгоо, эмчилгээний мэдээллийг дотоодод болон олон улсад цахимаар солилцох тогтолцоог бүрдүүлнэ.



-Эрүүл мэндийн оношилгооны чадавхыг тасралтгүй дээшлүүлж эмч, эмнэлгийн мэргэжилтнийг нарийн мэргэжлээр гүнзгийрүүлэн сургаж, иргэн бүр эрүүл мэндийн бүрэн оношилгоонд жил бүр үр дүнтэй хамрагдах боломжийг бүрдүүлнэ.

-Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, орон нутгийн болон бүх шатлалын эмнэлгүүдийн оношилгоо, эмчилгээний мэдээллийг дотоодод болон олон улсад цахимаар солилцох тогтолцоог бүрдүүлнэ.

-“Элэг бүтэн Баянхонгор” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” үндэсний хөтөлбөртэй уялдуулан эрт илрүүлгийг нэмэгдүүлж урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

-“Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг /ангина/ өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлж, “Эрүүл ирээдүй” хөтөлбөрийн хэрэгжилтийг 100 хувь хэрэгжүүлнэ.

-Аймгийн хэмжээнд нэвтрүүлсэн эмэгтэйчүүдийн товлотт дархлаажуулалтыг эрчимжүүлж, умайн хүзүү, хөхний хорт хавдраас сэргийлэх МУ-ын Засгийн газрын “Эрүүл Монгол” хөтөлбөрийг 100 хувь ханган хэрэгжүүлнэ.

*(Handwritten signatures)*

-“Чадварлаг эмч, эмнэлгийн мэргэжилтэн” хөтөлбөрийн хүрээнд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг гадаад, дотоодын сургалтад тасралтгүй хамруулах замаар, тэдний үр чадварыг дээшлүүлэн хэрэгжүүлнэ.


-Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, сүрьеэгийн халдварыг эрс бууруулах бодлого зохион байгуулалтын арга хэмжээ авч, дээрх өвчлөлөөр хамгийн бага өвчлөлтэй аймаг болно.

-ЕБС-ын хичээл сургалтын программаар дамжуулан өсвөр насны охидын нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдлэгийг эрс нэмэгдүүлэн охидын жирэмслэлтээс сэргийлэн, үр хөндөлт, төрөлтийг 30 хувь бууруулна.

-Ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрт нь үзүүлэх тогтолцоог бүрдүүлж, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлдэг системийг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлнэ.

- Аймгийн төвд дугуйн зам шинээр байгуулж, одоо ашиглаж байгаа спорт заал, цогцолборуудын цагийн хуваарийг уян хатан болгож нийгмийн бүлгүүдэд бүрэн үйлчлэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийнхээ эрүүл амьдралын хэв маягийг дэмжих бодлогыг баримтална.

-Зарим сумдад эмчлүүлэгч, үйлчлүүлэгчид ээлтэй, стандартын шаардлага хангасан эрүүл мэндийн төвийн барилга байгууламжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.



-Түргэн тусламжийн автомашины тоог нэмэгдүүлэн тухай бүр парк шинэчлэлт хийнэ.

-Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлгийг оновчтой, эрсдэлд суурилсан байдлаар тасралтгүй үргэлжлүүлж, дундаж наслалтын хүйсийн ялгаатай байдлыг багасгах бодлогыг хэрэгжүүлнэ.

-Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт мэдээлэх, сануулах хиймэл оюун ухаанд суурилсан системийг хөгжүүлж, салбарын цахим шилжилтийг эрчимжүүлнэ

- Эрүүл мэндийн даатгалыг багцын системд шилжүүлж, даатгуулагч өөрт хэрэгцээтэй багцыг сонгодог тогтолцоог нэвтрүүлэх ажлыг санаачлан хэрэгжүүлнэ.

-Уламжлалт анагаах ухааны салбарыг аялал жуулчлалын баримжаатай хөгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

-Эмийн чанар, үнэ аюулгүй байдал, үйлдвэрлэлтэй холбоотой мэдээллийг цахимаар авах, хянах боломжийг бүрдүүлсэн health.gov.mn цахим системийн хэрэглээг ард иргэдэд сурталчлах, хэрэглэх боломжийг нэмэгдүүлнэ.

### **1.4 Чанартай боловсрол шинжлэх ухаан, инновацын хөгжил**

Иргэдэд боловсролын үйлчилгээг хүртээмжтэй, тэгш, ялгаваргүй эзэмшүүлэх орчин бүрдүүлж, шинжлэх ухаан технологи, инновац шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээ, үйлдвэрлэлийг дэмжиж, хүүхэд бүрд чанартай боловсрол эзэмшүүлнэ.

-Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, 1-2 хүртэлх насны хүүхдийг яслийн үйлчилгээнд хамруулан ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

-Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролд бүрэн хамруулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд 6 цэцэрлэг, 7 сургуулийн барилгыг шаардлагатай газруудад шинээр барьж сургуулийн ээлжийн коэффициентийг тасралтгүй бууруулна.

-Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.

-Нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж, цахим сургалтын нэгдсэн платформ бий болгон хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлнэ.

-Мэдээллийн технологийн агуулгыг шинэчилж, хиймэл оюун ухаан, роботик, программчлалын мэдлэгийг ерөнхий боловсролын сургалтын агуулгад үе шаттайгаар оруулна.

- Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлэх бодлогыг дэвшүүлнэ.

- Цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгож сурах орчныг сайжруулах бодлого дэвшүүлнэ.

- Багш нарыг гадаад, дотоодод сургаж, мэргэжил дээшлүүлэх боломжийг нээлттэй болгох бодлого дэвшүүлж хэрэгжүүлнэ.

-Мэргэжлийн болон техникийн боловсролын сургуулийн сургалтын агуулгыг орон нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан зохион байгуулж, цахим болон танхимын хосолсон сургалтын хэлбэрийг дэмжинэ.

### **1.5.Тогтвортой-амар, амгалан гэр бүл**

- Хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хамгааллын үйлчилгээг сайжруулж, сум бүрд гэр бүл, хүүхэд хөгжил хамгааллын ажилтантай болгох саналыг дэвшүүлнэ.

-Хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлж, иргэдийн оролцоотой хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэн ажиллана.

-Залуучуудыг хөдөлмөрийн хуульд тусгагдсан цахимаар, зайнаас, гэрээс, цагаар ажиллах болон богино хугацааны хөдөлмөр эрхлэх боломжуудыг өргөжүүлж, шинэ ажлын байр бий болгох бодлогыг хэрэгжүүлнэ.

-Залуучуудын чөлөөт цагийг өнгөрүүлэх, хөгжих боломжит нөхцөлөөр хангахад зориулан залуучуудын хөгжлийн ордонтой болно.

-Залуу гэр бүлийг орон нутагт амьдрах боломжоор хангаж, орон сууцны ипотекийн 3 хувийн зээлд хамруулах хүртээмжийг нэмэгдүүлнэ.

-Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

-Ахмадуудад төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх төвийг байгуулж, ахмадад үйлчлэх төвийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.

-Зудад өртсөн малчдыг малжуулах хөтөлбөрийг эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлж, малын тоо бус чанарыг чухалчилна.

-Зудын эрсдэлийг даван туулах "Өвөлжөө" төсөл хэрэгжүүлнэ.

-Хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог сайжруулж, малчид, тариаланчдыг эрсдэлээс хамгаална.

-Идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлэх бодлогын хүрээнд "Аав", "Эрчүүд", "Чанартай амьдрал-аавуудын оролцоо" хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагууд, нийтийн эзэмшлийн зам талбайд 100 хувь мөрдүүлж, үйлчилгээний тэгш байдлыг хангана.

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

-Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлын түвшинг бууруулах бодлого баримтална.

-Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулна.

### 1.6. Үндэсний өв соёл

Үндэсний нэгдмэл үнэт зүйл, эх хэл, хонгор нутгийнхаа түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ

Үндэсний өв уламжлал, түүх, уран зохиол, нүүдлийн ахуйн соёлыг шингээсэн хөтөлбөр, уран бүтээл, дижитал контент бүтээгчдийг дэмжиж, соёлын боловсролтой, эерэг хандлагатай, бүтээлч иргэдийг төлөвшүүлэх "Бүх нийтийн соёлын боловсрол" арга хэмжээг хэрэгжүүлнэ.

-Соёл, урлагийн салбарыг мэргэжлийн хүний нөөцөөр хангах, чадавхжуулах, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ.

-Аймгийн түүх угсаатны зүйн музейн барилгыг шинээр барьж, түүх дурсгалын үзмэрүүдийг олон нийтэд таниулах ажлыг эрчимжүүлнэ.

-Түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, биет бус өвийг өвлөн уламжлагчдыг алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

-Тахилгат уул, ус, газар нутгийн мэдээллийн санг бүрдүүлж, тахин шүтэх ёсыг түгээн дэлгэрүүлнэ.

-Хүүхдийн театр, хүүхдийн номын сан, хүүхдэд зориулсан бүтээл зэрэг соёлын өвийг түгээн дэлгэрүүлж, хүүхэд хөгжлийн төвүүдэд шаардлагатай сургалт, танин мэдэхүйн дэмжлэг үзүүлнэ.

### **1.7.Спорт**

Нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулах, өсвөр үеийн шигшээ багийг бүрдүүлж дэмжлэг үзүүлэх, тамирчдыг бэлтгэх тогтолцоог сайжруулна.

-Орон нутагт ажилладаг магадлан итгэмжлэгдсэн спортын клубуудыг дэмжин хамтран ажиллана.

-Улс, тив дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчид, дасгалжуулагчдад дэмжлэг үзүүлнэ.

Улс, тив дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцож амжилт гаргасан үзүүлсэн тамирчдад дэмжлэг үзүүлэх


Ерөнхий боловсролын сургуулиудын биеийн тамирын талбайн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.

Хүүхэд залуучуудын дунд Е-Спортын аварга шалгаруулах тэмцээнийг жил бүр уламжлал болгон зохион байгуулж хүүхдүүдийн цахим боловсролыг нэмэгдүүлэх цогц бодлого хэрэгжүүлнэ.

Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжсэн иргэдийн спортын наадмыг жил бүр зохион байгуулах бодлогыг санаачлан дэвшүүлнэ.

### **"ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО"**

Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаснаар жижиг дунд үйлдвэрлэл, бизнесийн таатай орчин бүрдэж, иргэн бүрдээ хүрсэн, ядуурал буурч, дундаж давхарга зонхилсон, орон нутаг бие даан хөгжих засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоодын хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспортыг дэмжсэн бүс нутгийг хөгжүүлнэ.



*Handwritten signature*

*Handwritten signature*

*Handwritten signature*

## 2.1. Орон нутгийн төсөв мөнгөний бодлого

-Татварын бааз суурийг нэмэгдүүлснээр орлогыг нэмэгдүүлж аймгийн төсвийн бие даасан байдлыг дээшлүүлж, төсвийн зардалд эзлэх орон нутгийн орлогын хэмжээг 30 хувиар өсгөнө.

-Төсвийн ил тод байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ.

-Төсөв санхүүгийн нэгдсэн цахим системийн хэрэглээг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг шуурхай үр ашигтай хүргэж, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулна.

-Төсөвт байгууллагын санхүүгийн ажилтнуудыг чадавхжуулж, хүний нөөцийг бэхжүүлнэ.

-Төсөв, мөнгөний бодлогын оновчтой хослолоор эдийн засгийн сэргэлт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

-Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг үр өгөөжөөр нь эрэмбэлж, эдийн засгийн үр өгөөжтэй, ажлын байр бий болгох төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зарчим баримтална.

## 2.2. Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт уул уурхай

-Байгаль орчинд ээлтэй өндөр технологийн уул уурхай болон стратегийн ач холбогдолтой төслийг орон нутгаас дэмжинэ.

-Уул уурхайн лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг холбогдох газарт тавьж хүчингүй болгуулах саналыг дэвшүүлнэ.

-Уул уурхайн нөхөн сэргээх ажлын хяналтыг сайжруулж, нөхөн сэргээлт хийгээгүй аж ахуйн нэгжийн эрх бүхий албан тушаалтанд ногдуулах хариуцлагыг чангатгана.

-Уул уурхайн болон орон нутгийн хөгжлийн томоохон төслийг хэрэгжүүлэхийн өмнө хийгдэх БОНБУ-ний чанарыг сайжруулж, шаардлагатай тохиолдолд төслийг зогсоох хүртэл арга хэмжээг авна.

## 2.3. Дөрвөн улирлын аялал жуулчлал ба Соёлын бүтээлч үйлдвэрлэл

-Монголын нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, чанар, дизайныг сайжруулан тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлж, орон нутагт орох орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

-Аялал жуулчлалын гадаад, дотоодын маркетинг, сургалт, сурталчилгааг өргөжүүлж, олон улсад аймаг, орон нутгаа сурталчлах ажлыг эрчимжүүлнэ.

-Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн чиглэл рүү хөгжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.

-Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний цахим шилжилтийн хүрээнд дэвшилтэт технологийг (AR, VR, MR, 3D) ашиглаж “Цахим соёл” арга хэмжээг өргөжүүлнэ.

-Соёлын аялал жуулчлалын бүс, бүтээлч хот бий болгож, соёлын орон зай бүрдүүлнэ.

#### **2.4. Хөдөөгийн сэргэлт - “Шинэ хоршоо” хөдөлгөөн**

-“Шинэ хоршоо” хөдөлгөөнийг орон нутгийн хэмжээнд өрнүүлж, хоршоолохыг дэмжинэ.

-Хоршоодод олгож буй хамтын хариуцлагын 3-5 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

-Малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээг хоршоогоор дамжуулан үзүүлнэ.

-Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир боловсруулах цех байгуулах ажлын байрыг сум бүрд нэмэгдүүлэх бодлогыг баримтална.

#### **2.5. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, боловсруулалт**

-Малын түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх сум дундын хоршоог бүсчлэн байгуулж, малчид ашиг хүртдэг бодлогыг дэвшүүлнэ.

-Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах “Баянхонгорт үйлдвэрлэв” нэрийн томоохон цогцолбор байгуулж иргэдийн орлогыг нэмэгдүүлэх бодлого баримтална.

-Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.

-Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг хагас болон гүн боловсруулах, инновац, технологи шингэсэн “Цагаан алт” хөнгөн үйлдвэрийн цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах ажлыг санаачлан хэрэгжүүлэх бодлого баримтална.

-Мах ногооны 1000 тонны зоорь, өвлийн хүлэмж, ингэний сүүний үйлдвэр, малын тэжээлийн үйлдвэрүүдийн үйл ажиллагааг жигдрүүлнэ.

-Баянхонгор аймагт Олон улсын стандарт хангасан мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулах эхлэлийг тавьж, малчдын орлогыг нэмэгдүүлэх бодлогын баримт бичиг боловсруулан хэрэгжүүлнэ.

-Баянхонгор аймагт ноолуур угаах, самнах үйлдвэр байгуулах санаачилгыг дэмжиж бодлогоор хөгжүүлнэ.

-Аймгийн хүн амын хэрэгцээт нарийн болон хүнсний ногооны 70%-аас доошгүй хувийг бие даан хангадаг нөхцөлийг бүрдүүлнэ.

-Малын чанар, үүлдэр угсааг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ.

### **2.6 Эрүүл хүнс**

-Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах “ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

-Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд тавих хяналтыг өндөржүүлнэ.

-Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх замаар малчдын орлогын тогтвортой байдлыг хангана.

### **2.7. Бүтээн байгуулалт, дэд бүтэц**

-Дулааны станцыг ашиглалтад оруулж иргэдийн тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

-Багш хөгжих орчин, наркологийн үйлчилгээ, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйлчилгээний ажилчдын ажиллах орчныг сайжруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

-Баацагаан суманд орон сууцжуулах төслийн дэд бүтцийг үргэлжлүүлэн хийнэ.

-Зарим сумдын хүүхдүүдийн сурах орчныг үе шаттайгаар сайжруулах бодлого хэрэгжүүлнэ.

-Баянхонгор аймгийн сумдыг аймгийн төвтэй холбосон хатуу хучилттай авто замын ажлын ТЭЗҮ боловсруулна.

-Баянхонгор аймгийн сумдыг аймгийн төвтэй холбосон хатуу хучилттай авто замын ажлыг Төр хувийн хэвшлийн түншлэлд түшиглэн барьж байгуулна.

-Баянхонгор аймгийн төвд 40 км хатуу хучилттай авто зам барьж, агаар, хөрс орчны бохирдолгүй “Эко Баянхонгор хот” хөтөлбөр хэрэгжүүлнэ.


-Байдрагийн голд 25 МВт-ын усан цахилгаан станцыг барьж, ашиглалтад оруулж Баянхонгор аймгийн эрчим хүчний найдвартай байдлыг хангана.

-Баянхонгор сумын цэвэрлэх байгууламжийг шинэчлэн, өргөтгөх асуудлыг олон улсын төсөл хөтөлбөр, улсын төсвийн хөрөнгөөр шийдвэрлэнэ.

-“Сумын төвийн шинэчлэл” төслийг үргэлжлүүлнэ.

-Баянхонгор сумын дулааны 2 дугаар хэлхээний инженерийн шугам сүлжээг барих ажлыг эхлүүлж, иргэдийн ая тухай амьдрах орчныг сайжруулах бодлого баримтална.

-Баянхонгор сум, Шинэ суурьшлын бүсийн үерийн хамгаалалтын далан суваг барих ажлыг үе шаттай хэрэгжүүлж, иргэдийг үерийн эрсдэлээс хамгаалах бодлого баримтална.



-Агаар хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Баянхонгор сумын гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбох магистраль шугамын ажлыг дуусгана.

### **2.8.Авто зам**

- Баянхонгор–Баянбулаг–Улиастай чиглэлийн босоо тэнхлэгийн авто замын ажлыг санаачлан хэрэгжүүлнэ.


-Нарансэвстэйн боомтын үйл ажиллагааг сэргээж, Баянхонгор аймгийн Шинэжинст сумыг Нарансэвстэйн боомтын хатуу хучилттай авто замаар холбож бүс нутгийн хэмжээний хилийн гарцтай болгон бүтээгдэхүүний экспорт, импортыг нэмэгдүүлэн, аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын ТЭЗҮ боловсруулан.

- Баянхонгор хот - Цэцэрлэг хотыг хатуу хучилттай замаар холбон хотуудын хамтын ажиллгааг сайжруулах бодлого баримтална

-Баруун бүсийн тээвэр ложистикийн төв байгуулах ажлыг санаачлан үе шаттай хэрэгжүүлнэ.

-Түйн болон Байдрагийн голын шаардлагатай цэгт төмөр бетон гүүр барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх бодлого баримтална.

- Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн хатуу хучилттай зам тавих ажлыг үргэлжлүүлэх бодлого барина.



### **ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

Төрийн байгууллага бүрд төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангаж, чадваржуулан, төрийн албаны шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих боломж бүхий цахим системийг нэвтрүүлэх ба төрийн үйлчилгээг операторын үйлчилгээнд шилжүүлж, үйл ажиллагааг нь чанаржуулна.

Аймгийн нутаг дэвсгэрийн стратеги төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжүүлнэ.

-Төрийн албан хаагчийн “Сургалт, нийгмийн баталгааг хангах” стратеги төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлнэ.

-Нийгмийн хариуцлагаа ухамсарласан, хараат бус, мэргэжлийн сэтгүүл зүйг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэн, нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллана.

-Хүнсний бүтээгдэхүүний чанарын баталгааг сайжруулах зорилгоор орчин үеийн техник, технологийн лабораторитой болж иргэдийг эрүүл аюулгүй хүнсээр хангах бодлого баримтална.

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын нутгийн удирдлагын ордон барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэн, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг төвлөрүүлж, иргэд нэг цэгээс үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.



-БНХАУ-ын аймаг, мужуудтай хамтын ажиллагааг үргэлжлүүлж, бусад улсын хот, мужуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг үргэлжлүүлэх бодлого баримтална.

-Орон нутгийн нэгдсэн статистик мэдээлэл харуулах Удирдлагын самбар (Дашбоард) нэвтрүүлнэ.

-СӨХ-ийн ухаалаг систем нэвтрүүлнэ.

-Олон нийтийн цэцэрлэгт хүрээлэн болон нийтийн эдэлбэр газарт WIFI цэгүүд байгуулж, иргэд хүссэн газраасаа цахим орчинд нэвтрэх боломжийг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

### **ДӨРӨВ. ХҮН БА ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН**

Өвөг дээдсийн унаган байгалиа хайрлан хамгаалж, эх дэлхийтэйгээ харилцан шүтэлцэж ирсэн уламжлалт нүүдэлчин соёл иргэншлийг эдийн засаг, аж үйлдвэрийн Их сэргэлтийн эрин үед ногоон хөгжлийн жишиг загвар болгон тодорхойлж, дэлхий нийтийн чиг хандлагатай нийцүүлнэ.

#### **4.1. Уур амьсгалын өөрчлөлт**

-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр нөлөөг багасгах, байгальд ээлтэй оролцоотой ажил бизнесийг татварын бодлогоор дэмжинэ.

-Хүлэмжийг хийг бууруулах стратегийг утаа, эрчим хүч, өрхийн халаалтын шийдэл, цөлжилт зэрэг тулгамдсан асуудлууд руу чиглүүлж, олон улсын төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах санал, санаачилгыг дэвшүүлж ажиллана.

-Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, эко системийн тэнцвэрийг хадгалахад хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог санаачилна.

-Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг боловсронгуй болгож, төр хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлээр хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулна.

#### **4.2. Уламжлалт нүүдлийн аж ахуй ба сорилын бэрхшээл**

-Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах замаар ашиглагч малчдыг хариуцлагажуулна.

-Гэрээний дагуу даацаа хэтрүүлээгүй, зөв зохистой маллаж, бэлчээр хамгаалж байгаа малчдыг бага хүүтэй ногоон зээлд хамруулах боломжийг банк санхүүгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

-Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.

-Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэх ажлыг нэмэгдүүлнэ.

#### **4.3. Үнэт баялаг ус**

-Сум, суурин газрын хүн амыг шаардлага хангасан ундны усаар хангах хайгуул судалгааны ажлыг зарим сумдад хийнэ.

-Байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулж, ард иргэд, мал аж ахуй, зэрлэг амьтан, үйлдвэрлэлийн усан хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран судална.

-Уул уурхай, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын ундны гүний усны нөөц ашиглалтыг хязгаарлаж, гадаргын ус ашиглахыг дэмжинэ.

-Нөхөн сэргээлт хийдэг, дэвшилтэт техник технологи нэвтрүүлдэг, усыг дахин ашигладаг хариуцлагатай уул уурхайг дэмжих бодлогыг хөтөлбөр болгон хэрэгжүүлнэ.

-Уул уурхайд үйлдвэрлэлийн технологид хэрэглэсэн усыг дахин ашиглах, саарал ус нийлүүлэх төслийг дэмжинэ.

-Аймгийн 20 сумын усны сан бүхий газар, усан хангамжийн эх үүсвэрүүдийн хамгаалалтын бүсийн хил заагийг тогтоож баталгаажуулна.

-Их Богд уулын Улиатай, Битүүтэйн хөндийн голын усыг Хөнөгийн хоолойд буулгах инженерийн шугам сүлжээ байгуулах ажлыг судалж шийдвэрлүүлнэ.

#### **4.4. Шар шороон шуурга**


-Шар шороон шуурганы нүүдлийг зогсоох, цөлжилтийг сааруулах төсөл хөтөлбөр боловсруулан холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэн хамтарч хэрэгжүүлнэ.

-Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг орон нутагт эрчимжүүлж ойн чиглэлийн нөхөрлөл, мэргэжлийн байгууллага байгуулах санал санаачилгыг дэмжин ногоон байгууламжийн эзлэх хувь, чанарыг дээшлүүлнэ.

-"Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд айл өрх бүр эзэмшлийн газартаа мод тарих аян өрнүүлж, төрөөс дэмжлэг үзүүлдэг журам боловсруулж хэрэгжүүлнэ.

-Аймгийн шинэсэн ойн санд ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, байгалийн аясаар сэргэн ургах нөхцөлийг бүрдүүлнэ.

-Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлыг тогтмол явуулж, гангийн эрсдэлийг бууруулна.



#### 4.5. Ногоон эдийн засгийн шилжилт


-Хог хаягдлыг дахин боловсруулах, байгальд сөрөг нөлөөгүй аргаар устгах үйлдвэр барих төслийг дэмжин хамтран ажиллана.

#### ТАВ.ХОТ, ХӨДӨӨГИЙН ТЭНЦВЭРИЙГ ХАНГАХ БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлснээр эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдэд тулгуурлаж хөрөнгө оруулалтыг төлөвлөж, шинэ төвлөрлийн бүс, эдийн засгийн олон тулгуур, орон нутагт эдийн засаг тэлэх суурь тавигдсанаар Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт, хөдөлгөөн, агаарын болон орчны бохирдол, түгжрэл зэрэг тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд эерэг нөлөө үзүүлнэ. -

-Хангайн бүсэд хамаарах Баянхонгор, Архангай, Өвөрхангай аймгууд бүсчилсэн хөгжлийн дагуу Хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, Байгаль, түүх соёл, археологи, рашаан сувилал, шашны аялал жуулчлал, гадаад дотоодын худалдаа, тээвэр логистикийн төв байгуулан, харилцан ашигтай хамтран ажиллана.

-Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх байршлыг хамтран тогтоож, 4 хувийн аж ахуй, хоршоодыг дэмжинэ.



БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

